

“Хөгжлийн шинэ гарц” хөтөлбөр

Хөтөлбөрийн хүрээнд шийдвэрлэх зорилтууд

1. Төрийн шинэчлэл
2. Нээлттэй зах зээл хөтөлбөр
3. Ядуурлаас гарах гарц
4. Монгол улсын тусгаар тогтнолын бодит шийдэл
5. Сонгуулийн тогтолцооны шинэчлэл
6. Улс төрийн намын шинэчлэл
7. Авилга хээл хахуульгүй нийгэм
8. Утаанаас салцгаая шийдэл
9. Түлш шатахууны хүндрэлээс ангижиръя шийдэл
10. Үзэл баримтлалын сонголт уриалга

1. Төрийн шинэчлэл

Төр бол бодлого хэрэгжүүлдэг, нөхцөл хангадаг, стандарт тогтоодог, үйлчилгээ үзүүлдэг оюуны талбар. Гэтэл өнөөгийн төр маань материаллаг хэлбэр лүү гуйваад орчихсоноос шалтгаалж материаллаг сонирхол давамгайлсан, хувь хүмүүсийн материаллаг сонирхол хангагдах таатай хөрс суурь болон хувирсан байна.

Төрийг – эрх ашиг сонирхолыг хангадаг эрх мэдлээс холдуулъя, мөнгө санхүүтэй холбоотой бизнесийн үйл ажиллагаа явуулдаг хэлбэрээс нь салгая

Төрийг-бодлого, нөхцөл, стандарт, үйлчилгээ гэсэн оюунлаг хэлбэрт нь оруулъя.

Социализмын 70-н жил, Ардчилалын 20-н жил, нийт 90-н жил Монголд оршин тогтносон зүүний социал үзэл баримтлалын тогтолцооноос барууны либерал үзэл баримтлалын тогтолцоонд оруулах Төрийн шинэчлэлийг хэрэгжүүлэхийн тулд

1. Төрөөс аливаа бизнесийн үйл ажиллагааны эрх зөвшөөрөл олгодог явдлыг бүрэн хязгаарлах хууль эрхзүйн орчныг бий болгоно.
2. Төр ямар нэгэн бизнесийн үйл ажиллагаатай холбоотой эрх болон өмч эзэмшдэг явдлыг хуулиар хориглож, үүнтэй холбогдох нийгмийн бүх салбарт өмч хувьчлалыг бодлого, хууль эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.
3. Төсвийн хөрөнгөөр аливаа бизнесийн үйл ажиллагаатай холбоотой хөрөнгө оруулалт, санхүүжилт хийгддэг явдлыг хуулиар хориглон зохицуулалт хийнэ.

Төр бизнесийн үйл ажиллагаатай холбоотой эрх олгодог, өмч эзэмшдэг, бизнес эрхэлдэг социал үзэл баримтлалын тогтолцоог халсанаар төр цэвэршиж, зөвхөн бодлого хэрэгжүүлдэг нөхцөл хангадаг, стандарт тогтоодог, үндсэн үйлчилгээгээ үзүүлдэг либерал үзэл баримтлалын сонгодог хэлбэртээ шилжин орно. Үүний үр дүнд хувийн эрх ашиг



сонирхлоор төрийн эрх мэдэл рүү тэмүүлдэг тогтолцоо үгүй болж, оюунлаг чадварлаг төртэй, төрийн түшээдтэй болох нөхцөл хангагдахаас гадна төрийн одоогийн нүсэр тогтолцоо, хавтгайрсан халамжийн бодлого үгүй болж, төрийн алба цомхон чадварлаг байх боломж бүрдэнэ. Төр зөвхөн татвараа авч түүгээрээ үндсэн үйлчилгээ оюунлаг үйл ажиллагаагаа явуулах тогтолцоонд төсвийн бодлого шилжин орно. Ингэснээр одоогийн төсвийн зардал 30-50% огцом багасч, төсөв тогтмол ашигтай байх боломжтой болно.

2. Нээлттэй зах зээл хөтөлбөр

Байгалийн баялаг ашигт малтмалаа эцсийн бүтээгдэхүүн болгон дэлхийн зах зээлд нийлүүлэх, иргэдийн амьжиргааг хөгжингүй улс орнуудын иргэдийн амьжиргааны түвшинд богино хугацаанд хүргэх, Монгол улсыг дэлхийн эдийн засгийн глобальчлалын салшгүй нэгэн хэсэг болгон хөгжүүлэх зорилго ач холбогдол бүхий нээлттэй зах зээл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

Үүнийг хангахын тулд:

Монгол улс Европын холбоотой өндөр хэмжээнд харилцан ашигтай хамтын ажиллагааг хэрхэн өрнүүлэх талаар гадаад харилцааны бодлогоо шинээр тодорхойлж, шаардагдах хууль эрх зүйн орчныг бий болгох замаар нээлттэй зах зээл зорилтыг хэрэгжүүлнэ.

3. Ядуурлаас гарах гарц

Зах зээлийн нийгмийн хөгжлийн үндсэн хүчин зүйл болсон үйлдвэрлэл – худалдаа-үйлчилгээ гэсэн санхүү бизнесийн үйл ажиллагааг өндөр түвшинд явуулснаар зах зээлийн нийгмийг хөгжлийн хэмжээнд хүргэж, нийгмийн ядуурлыг арилгана.


Үүнийг хангахын тулд:

Үйлдвэрлэл - худалдаа – үйлчилгээ гэсэн санхүү бизнесийн үйл ажиллагаа өндөр түвшинд явагдах гол нөхцөл болсон зах зээлийн багтаамж, худалдан авах чадварыг хангах хууль эрх зүйн дэмжлэг, шийдлийг бодлогын хүрээнд гаргана. Энэ бодлого хэрэгжсэнээр худалдан авах чадвар бүхий иргэдтэй нээлттэй зах зээлтэй хөгжингүй Монгол улс бий болж, нийгмийн ядуурлаас гарах зорилт хэрэгжинэ.

4. Монгол улсын тусгаар тогтнолын бодит шийдэл

Дэлхийн хүчирхэг 2 хөрш гүрний Монголын талаар авч явуулж буй хамтарсан бодлогын үр дүнд Монголчууд бид Ар, Өвөр буриад, Тува, Халимаг хэмээн задран хуваагдаж, зөвхөн бидний цөөхөн Монголчууд энэ 2 гүрний дунд өрсөлдөгч нь болж чадахааргүй хэмжээнд өс төдий тусгаар тогтнолтой оршин тогтнож байна.

Өнөөгийн бидний тусгаар тогтнол бол хөрш улсуудад байгаа монголчуудаараа сольж авсан золиосны тусгаар тогтнол, биднийг нэг мөсөн үгүй болгох тэр цагийг хүлээж буй түр зуурын тусгаар тогтнол. Ийм нөхцөлд хөрш 2 улсыг аялдан дагасан өнөөгийн төрийн



бодлого монгол улсын тусгаар тогтнолыг улам л хэврэг, эмзэгхэн болгохоос хэтрэхгүй байна.

Тусгаар тогтнолоо бодит баталгаатай болгохын тулд

1. Монгол улс энэ 2 хөрш гүрэнтэй эн зэрэгцэхүйц томоохон хүчний харилцан ашигтай хамтын ажиллагаанд суурилсан өмгөөлөлд орох явдал нь бие даан тусгаар тогтнолоо хамгаалах хүчин чадалтай болох тэр цагийг хүртэл авч явуулах тусгаар тогтнолын бодит шийдэл юм. Ийм хүчин бол Европын холбоо хэмээн үзэж энэ холбоотой уг асуудлаар хэрхэн хамтран ажиллах гарц шийдлийг хөтөлбөрөөр гарган тавьж байна.
2. Монгол улс АНУ-тай томоохон ашиг сонирхол дээр тулгуурласан харилцааг бий болгож чадвал нутаг дэвсгэр дээрээ АНУ-гийн цэргийн бааз, пуужингийн довтолгооноос хамгаалах системийг байршуулах асуудлыг шийдвэрлэх боломжтой болох юм. Монгол улсын Үндэсний аюулгүй байдал тусгаар тогтнолыг гэрээгээр хамгаалах үүргийг АНУ-д хүлээлгэснээр өөрсдийгөө бие даан хамгаалах хүчин чадалтай болтлоо уужуу амьсгаа авч болохоос гадна нутаг дэвсгэртээ байршуулах гэрээний дагуу АНУ-аас Монгол улсад орж ирэх түрээс төлбөрийн хувьд ч төсөв эдийн засагт эерэгээр нөлөөлнө.


Эдгээр шийдлүүдийг хэрэгжүүлэх үүднээс холбогдох хууль эрхзүйн орчны шинэчлэлт өөрчлөлт, гадаад харилцааны бодлогыг шинээр тодорхойлох зэрэг асуудлуудыг хэрэгжүүлнэ.

5. Сонгуулийн тогтолцооны шинэчлэл

1. Сонгуулийн тогтолцоо ямар байна, тийм л нийгэм байдаг зүй тогтол нь өнөөгийн монголын нийгмийн үнэн дүр төрхтэй нийцэж байгаа бөгөөд одоо үйлчилж буй мажоритар системийг өөрчилж бүтэн пропорционал сонгуулийн тогтолцоонд орох явдал хичнээн чухал болохыг энэ нь харуулж байгаа. Харамсалтай нь Монгол улсын Үндсэн хуулинд мажоритар системийг хүлээн зөвшөөрсөн, бусад системийг үгүйсгэсэн байна.
2. Шударга сонгуулийн тогтолцоог бий болгоход дутагдаж буй гол асуудал нь санал тоолох ажиллагааны шийдэл. Шинээр батлагдсан сонгуулийн хуулинд санал тоолох ажиллагааг автоматжуулсан нь автомат луйвар гарах бололцоог нээж өгсөн байна.

Сонгуулийн тогтолцоог шинэчлэхийн тулд

1. Үндсэн хуулин дахь дээр дурдсан заалтыг өөрчилж, үүний дагуу сонгуулийн бүтэн пропорционал тогтолцоог агуулсан хууль эрхзүйн орчныг бий болгох.



2. Автоматжуулалтын хуулийг хүчингүй болгож, санал тоолох ажиллагааг камерын нээлттэй хяналтын систем бүхий гар ажиллагаанд оруулан хуульчлах

Эдгээрийн үр дүнд төрийн төлөвшил, улс төрийн намуудын төлөвшил хангагдахад хүчтэй нөлөөг үзүүлж, цэвэр улс төрийг нийгэмд бий болгох, сонгуулийн шударга тогтолцоог хангах боломжтой болохоос гадна сонгуулийн үйл ажиллагаанд их хэмжээний хөрөнгө зарцуулдаг одоогийн механизм үгүй болсноор төсвийн хэмнэлтэнд эерэг нөлөөг үзүүлнэ.

6. Улс төрийн намын шинэчлэл

Монгол улсын үндсэн хууль, Улс төрийн намын тухай хууль, Сонгуулийн хууль гэсэн хуулиудын одоо мөрдөгдөж буй тогтолцоо зарим зүйл заалтын үр дагавраас шалтгаалж Монгол улсад улс төрийн намын төлөвшил өнөөг хүртэл хангагдаж чадсангүй. Төрийн үйл ажиллагаа өнөөгийн бохир тогтолцоонд орчихсон нь үүнээс үүдэлтэй. Улс төрийн намууд ямар байна тийм л төр байдаг, төр ямар байна тийм л нийгэм байдаг зүй тогтолтой нь холбон авч үзвэл улс төрийн намын төлөвшлийг хууль эрхзүйн хүрээнд хангах явдал хичнээн чухал болох нь үүнээс харагдаж байна.

Улс төрийн намын төлөвшлийг хангахын тулд


1. Сонгуулийн пропорционал тогтолцоонд шилжин орсноор сонгуулиар улс төрийн намд хариуцлага тооцох механизм бодит утгаараа бий болж, энэхүү хариуцлагын хүчтэй тогтолцоо нь улс төрийн намыг төлөвшихөд чухал нөлөөг үзүүлнэ.
2. Сонгуулийн пропорционал тогтолцоотой хамтатган улс төрийн намын тухай хуулийг шинэчлэн өөрчилсөнөөр улс төрийн намыг төлөвшүүлэх зорилго бүрэн хангагдана.

7. Авилга хээл хахуульгүй нийгэм

Манай нийгэмд бугшаад буй бас нэгэн хүндрэлтэй асуудал нь авилга хээл хахууль. Нийгмийг шудрага бус тогтолцоо руу чирэн оруулдаг энэхүү аюулт үзэгдлийн бий болж цэцэглэн хөгждөг орон зай нь төр өөрөө байдаг. Материаллаг сонирхолтой холбоотой эрх мэдэл болон бизнесийн үйл ажиллагаа түүнтэй холбогдох томоохон өмчлөл төрд хэдий чинээ их байна, төдий чинээ авилга хээл хахуульд төр идэгддэг. Энэ их эрх мэдэл, өмчлөлөөс нь төрийг салгахгүйгээр авилга хээл хахуультай тэмцэх ямар ч боломжгүй.

Авилга хээл хахуульгүй нийгмийг бий болгохын тулд

1. Авилга авсан, өгсөн, зуучилсан талуудыг нягт гинжин холбоонд оруулж буй өнөөгийн хуулийн тогтолцоог өөрчилж, эдгээр талуудын авилгын харилцааг хэврэг сул найдваргүй тогтолцоонд оруулах хуулийн шийдлийг бий болгоно.



2. Материаллаг сонирхолтой холбоотой эрх мэдэл болон бизнесийн үйл ажиллагаа, түүнтэй холбогдох өмчлөлөөс төрийг бүрэн салгах бодлого хууль эрхзүйн шинэчлэлийг хийнэ.
3. Шүүх хуулийн байгууллагын хүрээн дэх авилгын асуудлыг ялын бодлогоор шийдвэрлэнэ.

Эдгээрийг цогцоор нь шийдвэрлэсэнээр авилгагүй нийгмийг бий болгож чадна.

8. Утаанаас салцгаая шийдэл

Төрөөс Улаанбаатар хотын утааны асуудлыг шийдвэрлэх зорилгоор төсвийн их хэмжээний хөрөнгө мөнгийг олон жилийн турш зарцуулсаар ирсэн ч утаа огт багассангүй, харин ч улам бүр нэмэгдсээр байна.

Утаагүй Улаанбаатарыг бий болгохын тулд


Гэр хорооллыг орон сууц хэмээх нийтийн байр болгон өөрчлөлгүйгээр иргэдийн өөрсдийнх нь идэвхи санаачлага дээр дөрөөлөн халаалт дулаан бохирын асуудлаа бие даасан системээр шийдсэн өөрийн эдлэн газар бүхий амины орон сууцны хотхон болгон хөгжүүлэх нөхцөлийг бодлого хууль эрхзүйн хүрээнд тавьж өгнө. Ингэснээр гэр хорооллын газар чөлөөлөх, орон сууцны нүсэр дэд бүтэц байгуулах зэрэг төсвийн хөрөнгө санхүү шаардсан хүндрэл бэрхшээлгүйгээр, иргэдийн өөрсдийнх нь бие даасан санхүүжилтээр илүү хялбархнаар утааны асуудлыг шийдвэрлэх боломжтой болох юм.

9. Түлш шатахууны хүндрэлээс ангижиръя шийдэл

Зах зээлийн багтаамж, худалдан авах чадвар муу өнөөгийн нөхцөлд аливаа худалдаа эрхлэгчдийн хувьд монополь түвшинд очиж байж өндөр ашигтай байж чаддаг. Энэ зүй тогтол нь түлш шатахууны худалдаа эрхлэгчдийг монополь хэлбэрт түлхэн оруулахад гол түлхэц нь болж өгснөөр өнөөдөр манайд хэдхэн тооны компаниуд энэ зах зээлийг бүрэн хяналтандаа оруулж дуртай цагтаа үгсэн хуйвалдах замаар үндэслэлгүй үнэ хөөрөгдөн, үүнээс үүдсэн зах зээл дэх бүх төрлийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, нийгмийн бухимдлыг зохиомлоор бий болгож байна. Мөн түлш шатахууны импортын хараат байдал валютын үнэ ханшийн савалгаа зэрэг нь ч үүнд давхар нөлөөлж байгаа юм.

Түлш шатахууны хүндрэлээс ангижрахын тулд

1. Жижиглэнгийн болон бөөний худалдааг бодлогоор задлах
2. Валютын үнэ ханшийн савалгаанд бага өртөхийн тулд энэ чиглэлийн худалдааг бартерын хэлбэрт оруулахад шаардагдах гадаад худалдааны харилцааг төрийн зүгээс авч явуулах



3. Дотооддоо нефть хийн хайгуулыг эрчимтэй хийх, импортын олон сувгийг бий болгох, нүүрснээс шингэн түлш гарган авах технологийг нэвтрүүлэх зэрэгт гадаад дотоодын хөрөнгө оруулагчдыг татах, хөхүүлэн дэмжих бодлогыг хууль эрхзүйн хүрээнд шийдвэрлэх

10. Үзэл баримтлалын сонголтоо хийцгээе уриалга

“Хөгжлийн шинэ гарц” хөтөлбөр нь барууны чиглэлийн либерал үзэл баримтлал дээр суурилсан гарсан, энэхүү үзэл баримтлалын сонгодог жишээ юм. Монгол улс өнөөг хүртэл зүүний чиглэлийн социал үзэл баримтлалын бодлогоор явж ирсэн нь нийгмийн бүхий л асуудлыг зөвхөн төрөөс хамааралтай болгож, төрийн бохир тогтолцоо, тусгаар тогтнолын эмзэг хэврэг шинж, нийгмийн ядуурал, төвлөрсөн төлөвлөгөөт социалист эдийн засаг, сонгуулийн шударга бус тогтолцоо, улс төрийн намын ялзрал, авилга хээл хахуулийн цэцэглэлт, агаарын бохирдол, байгаль орчин экологийн сүйрэл, түлш шатахуунаас хамаарсан нийгмийн бүхий л салбарын хүндрэл зэрэг ноцтой сөрөг үр дагавруудыг бий болгон амилууллаа. Нийгмийн бухимдлын гол шалтгаан энэ үзэл баримтлалаас ийнхүү хамаарч байна. Энэ бүгдийг цогцоор нь өөрчлөхийн тулд өнөөг хүртэл дагаж ирсэн социал үзэл баримтлалын сонголтоо өөрчилж либерал үзэл баримтлалын үндсэн зарчмыг амьдралд хэрэгжүүлэх “Хөгжлийн шинэ гарц” хөтөлбөрт нэгдэцгээе.

